

ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ БАЙГУУЛЛАГЫН АЛБА ХААГЧДЫГ БЭЛТГЭХ СУРГАЛТЫН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ ЗАРИМ АСУУДАЛ

Ц.МӨНХБАЯР

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
8022 дугаар дамжааны суралцагч, цагдаагийн хошууч;

Д.Түмэндэлгэр

ХСИС-ийн Хууль сахиулахын удирдлагын академийн
Удирдахуйн ухааны профессорын багийн ахлах багш,
цагдаагийн ахмад

Хураангуй: Энэхүү илтгэлээр шүүхийн шинжилгээний байгууллагад зохион байгуулагдаж байгаа албаны болон мэргэжлийн сургалтын өнөөгийн байдал тулгамдсан асуудлыг судлан цаашид алба хаагчдын хэрэгцээнд нийцсэн, бодит үр дүн бүхий, хүртээмжтэй сургалтыг зохион байгуулах боломжийг эрэлхийлсэн болно.

Түлхүүр үг: Шинжээч, шинжээчийн мэргэжлийн мэдлэг, мэргэжлийн тусгай мэдлэг

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2016 оны А/42 дугаар тушаалаар баталсан Шүүхийн шинжилгээний байгууллагын бүтэц, орон тооны дээд хязгаарыг 514 алба хаагчтай байхаар баталсан бөгөөд Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн 203, Нийслэлийн шүүхийн шинжилгээний газар 93, Аймгийн шүүхийн шинжилгээний албанд 218 алба хаагч байхаар бүтэцлэн тогтоожээ.¹

**Шүүхийн шинжилгээний байгууллагын алба
хаагчдын орон тоо /Нийт 514/**



Өнөөгийн шинжлэх ухаан, техник, технологи, бизнесийн орчны эрс өөрчлөлтөд зохицон ажиллахын тулд байгууллагууд алба хаагчдынхаа мэдлэг, чадвар, чадамжийг байнга тасралтгүй дээшлүүлж байхыг шаардаж байна. Орчин үед аливаа мэргэжилдээ чадварлаг хүний байгууллага дах үнэ цэнэ өндөр, хангалттай хэмжээний цалин. урамшуулал авах боломж нээлттэй, ажлын

¹Т.Очирбат. Шинжлэн магадлахуй. УБ., 2014.

гүйцэтгэл, байгууллагад оруулах хувь нэмэр төдий хэмжээнд өндөр байдаг нь батлагдсан зүйл билээ. Алба хаагчийн чадавхи нь мэдлэг, чадвар, хандлага, байгууллагын үйл ажиллагааг мэргэжлийн түвшинд зохин байгуулах боломж гэсэн ойлголтуудыг багтаадаг.


Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчийг сургаж бэлтгэх үйл ажиллагааг тоймлон авч үзвэл одоогийн Хууль сахиулахын их сургууль /ХСИС/-ийн түүхэн замналтай салшгүй холбоотой.

БНМАУ-ын Ардын сайд нарын зөвлөлийн /хуучин нэрээр/ 1933 оны 7 дугаар сарын 6-ны өдрийн 8 дугаар тогтоолоор дотоодыг хамгаалах газрын дунд сургууль байгуулах шийдвэрээр 1934 оны 09-р сарын 19-ний өдөр Дотоодыг хамгаалах газрын даргын 687 дугаар тоот тушаалын дагуу сургуулийн захирлыг томилон орон тоог батлан “Төв сургууль” байгуулагдсан цагаас одоог хүртэл дотооддоо гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журмыг хамгаалах мэргэжлийн алба хаагчдыг бэлтгэж байна.

Монгол Улсад хэргийн газрын үзлэг хийх, ул мөр, эд мөрийн баримт илрүүлж бэхжүүлэх, түүнд үзлэг шинжилгээ хийх мэргэшсэн шинжээч, мэргэжилтнийг сургаж бэлтгэх чиглэлээр 1992-1993 оны хичээлийн жилээс эхлэн Цагдаагийн дээд сургуульд элсэгчдээс 22 сонсогчийг сонгон шалгаруулж, криминалистикийн гүнзгийрүүлсэн сургалттай анги нээн хичээллүүлсэн нь дээд боловсролтой мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх анхны оролдлого байв.¹ Цагдаагийн ерөнхий газрын даргын 2000 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 146 дугаар тушаалаар Цагдаагийн академид “Криминалистикийн шинжилгээний тэнхим” гэсэн шинэ тэнхим байгуулагдаж өдгөө Хууль сахиулахын их сургуулийн харьяа “Шинжлэн магадлах институт” болон өргөжин хөгжиж Боловсрол, соёл, шинжлэх ухааны яамны сайдын 2003 оны 181 тоот тушаалаар "Г)86020Г"индекс бүхий “Криминалистикийн шинжээч-эрх зүй”, “В103204”индекс бүхий “Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил” мэргэжлээр 6 удаагийн төгсөлтөөр бэлтгэсэн бакалаврын зэрэгтэй 165 мэргэшсэн шинжээч, 51 магистр зэрэгтэй шинжээчдийг бэлтгэжээ*².

¹Хууль сахиулахын их сургууль Цагдаагийн сургууль, Шинжлэн магадлахуйн тэнхим 15 жил. УБ, 2015 он. 35 дэхьтал.

²Хууль сахиулахын их сургууль.Шинжлэн магадлахуйн тэнхим. 2015 он.




Шүүхийн шинжилгээний байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан, мэргэшүүлэх сургалтын тогтолцоог үе шаттай хэрэгжүүлж ирсэн байна. Тухайлбал, 2018 оны 10 сарын байдлаар Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиалгаар Хууль сахиулахын их сургуулийн “Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил” мэргэжлээр бакалаврын боловсрол эзэмшүүлэх сургалтад 2 дугаар дамжаанд 19, 3 дугаар дамжаанд 28, 4 дүгээр дамжаанд 29 сонсогч тус тус суралцаж байна. Мөн Хууль сахиулахын их сургуулийн Хууль сахиулахын удирдлагын академид 8. Ахисан шатны боловсролын сургуулийн магистрын сургалтад 12, хууль сахиулах болон бусад их дээд сургуулийн докторын сургалтад 8, “Цагдаа-хууль сахиулах ажил” бакалаврын боловсрол олгох эчнээ дамжаанд 8 алба хаагч суралцаж байгаа нь хүний нөөцийг сургаж бэлтгэх үйл явц тогтвортой тасралтгүй зохион байгуулагдаж байна.

1963 онд анх 10 хүнийг Криминалист-хэрэг бүртгэгчийг тусгай програмаар бэлтгэж Хэнтий, Дорнод, Завхан, Өвөрхангай, Төв, Дорноговь, Улаанбаатар хотод томилож ажиллуулж байсан бөгөөд үүний дараа богино хугацааны дамжаагаар сурган бэлтгэж, цагдан сэргийлэх ангиудад хуваарилан ажиллуулсан байна. 1990-ээд онд улсын хэмжээнд криминалистик мэргэжилтнээр хангагдаж байсан боловч гэмт хэргийн өсөлт, гаралтын улмаас дахин хүний нөөцийн хомсдолд орох болжээ. Энэ үед Криминалистикийн шинжилгээний төвд дамжаа хичээллүүлж 22 алба хаагчийг сургаж төгсгөсөн байна.

Криминалистикийн мэргэжлийн шинжээч анх бэлтгэж эхэлсэнээс хойш дахиж дээд боловсролтой шинжээч бэлтгэх үйл ажиллагаа дотооддоо зохион байгуулагдаагүйн улмаас хүний нөөцийн хомсдолд орж хэргийн газрын үзлэг хийж ул мөр, эд мөрийн баримт илрүүлж, бэхжүүлэх, хэргийн газрын үзлэгийн гэрэл зураг дүрс бичлэг хийх чадварыг эзэмшүүлэх дамжааг 2001 оноос эхлэн Цагдаагийн академид хичээллүүлж 4 удаагийн сургалтаар 101 криминалистикийн мэргэжилтэн бэлтгэсэн байна. Эдгээр мэргэжилтнүүд нь зөвхөн хэргийн газрын үзлэг дээр ажиллах бөгөөд криминалистикийн


шинжилгээ хийх эрхгүй бөгөөд хууль эрх зүй, болон бусад чиглэлээр дээд боловсрол эзэмшсэн мэргэшсэн алба хаагчид юм.

Монгол Улсад Криминалистикийн шинжээч, мэргэжилтнийг дараах тогтолцоогоор бэлтгэж байна.



Хууль сахиулахын их сургуулийн Шинжлэн магадлахуйн институтид "Шүүх шинжилгээ-хууль сахиулах" сургалтын төлөвлөгөөний нийт багц цаг 147 бөгөөд үүнээс ерөнхий суурь багц цаг 36 буюу 24,5 хувь, мэргэжлийн суурь багц 33 буюу 22,5 хувь, мэргэжлийн багц 78 буюу 53,0 хувь байна.

**"Шүүх шинжилгээ-хууль сахиулах" мэргэжлийн сургалтын
багц цаг /нийт 147 багц цаг 100%/**




Ерөнхий суурь хэсгийн агуулга нь суралцагчид "Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил" бакалаврын боловсрол эзэмшихэд зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх, мэргэжлийн суурь хэсгийн агуулга нь суралцагчид "Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил" бакалаврын боловсрол

эзэмшихэд зайлшгүй шаардлагатай онол-арга зүйн мэдлэг, чадвар эзэмшүүлэх, мэргэжлийн хэсгийн агуулга нь суралцагчид хувийн болон нийгмийн, шүүхийн шинжилгээний байгууллагын хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн “Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил” бакалаврын мэргэжлийн мэдлэг, чадвар. дадал эзэмшүүлэхэд чиглэгдсэн байна.

Мөн сургалтын тогтоцооны нэг хэсэг нь байгууллагын дотооддоо хийх сургалтууд юм. Байгууллагын дотооддоо зохион байгуулж буй сургалт нь алба хаагчдыг ажлын байран дээр нь тасралтгүй хөгжүүлэх зорилго бүхий, шинэ мэдлэг, арга зүйг эзэмшүүлдэг өвөрмөц хэлбэр юм. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс 2017 онд нийт дотоод гадаадын 37 сургалтыг зохион байгуулж мөн сургалтад хамрагдсан бөгөөд байгууллагын алба хаагчдад 32 удаа, тус байгууллагаас бусад хууль сахиулах байгууллагын алба хаагчдад 5 удаагийн сургалт явуулсан байна. Сургалтын агуулгыг авч үзвэл харилцааны ур чадвар, соёл, хандлагын чиглэлээр 5, Ерөнхий мэдлэг, мэдээллийн 3, Цэргийн хэргийн мэдлэгийн 3, Хууль, эрх зүйн 13, мэргэжлийн 13 сургалтыг зохион байгуулсан байна.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгээс зохион байгуулсан сургалт

- | | |
|------------------------------------|----------------------------|
| ■ Харилцаа, хандлага, соёл, ёс зүй | ■ Ерөнхий мэдлэг, мэдээлэл |
| ■ Цэргийн хэргийн мэдлэг | ■ Хууль эрх зүй |



Дээрх судалгаанаас үзэхэд алба хаагчдад хууль эрх зүй болон мэргэжлийн сургалт давамгайл зохион байгуулагдаж байна.

Дээрх сургалтуудаас үзэхэд Шүүх шинжилгээний шинжээч, мэргэжилтэн бэлтгэх, сургах, хөгжүүлэх чиглэлээр дотооддоо сургалтуудыг хангалттай хэмжээнд зохион байгуулж байгаа нь харагдаж байна.

Шүүхийн шинжилгээний байгууллага нь дотооддоо шинжээч, мэргэжилтэн бэлтгэхээс гадна хамтын ажиллагаатай улс орнуудад шинжээч, мэргэжилтэн бэлтгэж ирсэн түүхэн уламжлалтай.

1942 онд Цагдан сэргийлэх газрын Гүйцэтгэх хэлтсийн “хээ шинжлэгч”-ээр ажиллаж байсан нэр бүхий хүмүүсийг гарын хээний шинжилгээ, шүүх гэрэл зургийн чиглэлээр тодорхой хэмжээнд бэлтгэгдэж байсан бөгөөд тэдний нэг Д. Адилбишийг Челябинскт Чекистийн дактилоскопид суралцуулсан явдал юм.

Д. Адилбиш нь тус сургуулийг төгсөж ирээд 1944 онд Шинжлэн магадлах техникийн тасгийн даргаар томилогдон ажилласан байна. 1950-аад оны үеэс гэмт хэргийн төрөл, гэмт хэрэг үйлдэх арга нэмэгдэж түүнийг шинжлэх ухааны үндэслэлтэй нотлон тогтоох, криминалистикийн шинжлэх ухааныг хөгжүүлж өргөжүүлэх хэрэгцээ шаардлага гарсны улмаас НАХЯ-ны сайдын 1955 оны 8 сарын 16-ны өдрийн 452 тоот тушаалаар Т. Мою, Д. Дамба, нарыг 1957 оны 8 сарын 23-ны өдрийн 536 тоот тушаалаар Г. Гүндийжав, Ц. Сэлэнгэ нарыг ЗХУ-д Криминалистикийн дунд сургуульд явуулж суралцуулжээ.¹ Үүнээс хойш дунд болон дээд мэргэжилтэй боловсон хүчнийг бэлтгэх ажил үргэлжилсээр өнөөг хүрчээ.

Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэнгийн захиалгаар Оросын Холбооны Улсын Дотоодыг хамгаалах яамны харьяа их, дээд сургуулийн бакалаврын сургалтын хэлний бэлтгэлд 5 сонсогч, Мансууруулах бодисын хууль бус эргэлттэй тэмцэх албаны сибирь дэх хуулийн институтийн 3 дугаар дамжаанд 1, 2 дугаар дамжаанд 2, Дорнод Сибирийн дээд сургуульд 2, Волгоградын академийн 2 дугаар дамжаанд 4, 3 дугаар дамжаанд 5, 4 дүгээр дамжаанд 2 сонсогч, Удирдлагын академид 1 албан хаагч суралцаж байна.

Хүний нөөцийг бэлтгэх, давтан сургах бакалавр, магистр, докторын сургалтыг олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн орон бүхий Оросын холбооны улсад мэргэжилтэн бэлтгэж буй нь сайшаалтай хэрэг боловч бусад Европ, Азийн орнуудад бакалавр, магистр, докторын сургалт тогтвортой явагдахгүй байна.

Хэргийн газрын үзлэгт ганц криминалистикийн шинжээч, мэргэжилтэн оролцохоос гадна шинжлэх ухааны бусад салбарын төрөл мэргэжлийн мэргэжилтнүүд, тухайлбал шинжээч эмч, химич, физикч, биологич, инженер техникийн тусгай мэргэжлийн алба хаагчид оролцдог онцлогтой алба юм.

Гэмт хэрэг илрүүлэхэд байгаль, техникийн шинжлэх ухааны олотыг ашиглах асуудал криминалистикийн шинжлэх ухаан үүсэж бий болохоос өмнө эхэлжээ. Тухайлбал хими, биологийн ухааныг гэмт хэрэг илрүүлэхэд ашиглаж буй туршлага 1964 оноос эхлэлтэй бөгөөд 2005 онд Шүүх шинжилгээний

¹Т.Очирбат. Шинжлэн магадлахуй. УБ, 2014 он. 126 дах тал.

байгууллагууд нэгдсэн тогтолцоонд шилжиж хими, физик, биологийн лаборатори байгуулж ажиллахад байгалийн шинжлэх ухааны чиглэлээр бэлтгэгдсэн мэргэжилтэн, одоогийн хими, физик, биологийн тусгай лабораториуд байгуулагдан ажиллах үндэс болжээ.

Монгол улсын шүүх эмнэлгийн салбарын хөгжилд тухайн үеийн Зөвлөлт Холбоот Улсын эмч, мэргэжилтнүүд ихээхэн үүрэг гүйцэтгэж, Монгол Улсын Их Сургуульд багшилж байсан тус улсын эрдэмтэн, багш нар шүүх эмнэлгийн шинжилгээний задлан шинжилгээ хийх, гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээ зэргийг хийж дүгнэлт гаргасан байдаг. Энэхүү мэргэжлийн суурь болгон 1944 оноос эмгэг анатомийн хичээл, 1946 оноос Шүүх эмнэлгийн хичээлийг орж эхэлсэн бөгөөд одоогоор шүүх эмнэлгийн шинжээч, мэргэжилтнийг Анагаах ухааны үндэсний их сургууль болон анагаах ухааны чиглэлийн бусад их, дээд сургуульд бэлтгэж байна.

Харин шүүхийн шинжилгээний байгууллагад ХСИС-иас бусад их сургууль төгссөн мэргэжилтэн давтан сургалтад хамрагдаагүй, шинжилгээ хийх эрх олгосон мэргэжлийн гэрчилгээгүй шинжээчээр томилогдож байгаа явдал юм. Энэ нь тухайн шинжээч тусгай мэдлэг ашиглан дүгнэлт гаргах процессын эрх зүйн оролцогчийн шаардлага, улмаар шинжээчийн дүгнэлтэд тавих нотлох баримтын тусгай шалгуурын хүний хүчний үзүүлэлтийг хангахгүйд хүрнэ гэсэн үг.

Иймд шүүхийн шинжилгээний байгууллагад шинээр томилогдох шинжээч шинжилгээ хийж, дүгнэлт гаргах эрх авахын тулд ХСИС-д суралцан, эрх зүй-криминалистик, шинжлэн магадлахуйн тусгай мэдлэгийг эзэмшиж, гэрчилгээ эзэмшсэн байх нь зүй ёсны шаардлага юм.

ХСИС-иас хэрэгжүүлж мэргэжлийн буюу "Шүүх шинжилгээ-хууль сахиулах ажил" бакалаврын сургалтын хөтөлбөрийн хүрээнд бэлтгэгдэж байгаа Криминалистикийн шинжээч" мэргэшсэн чиглэлээс гадна цаашид "Химийн шинжээч", "Биологийн шинжээч", "Физикийн шинжээч", "Шүүх эмч", "Шүүх нягтлан бодох бүртгэлийн шинжээч" зэрэг шүүхийн шинжилгээний байгууллагын үйл ажиллагаанд нэн хэрэгцээтэй, мэргэшсэн шинжээч бэлтгэх шаардлагатай байна.

ХСИС-д бэлтгэсэн "шинжээч" зөвхөн ШШҮХ-д ажиллахаар хязгаарлагдахгүй, хил хамгаалах, онцгой байдал, мэргэжлийн хяналт, гааль, иргэний бүртгэл зэрэг төрийн бусад албадад шинжээчийн тусгай мэдлэгийн хүрээнд гүйцэтгэх ажил үүрэг, хэрэгцээ байсаар байна.

Түүнчлэн одоогийн хэрэгжиж буй сургалтын хөтөлбөрийг баяжуулан хими, физик, биологи, ДНХ-ийн шинжилгээ, барилгын болон авто инженерийн шинжилгээ, дуу авиа судлал, дижитал магадлах зүй, профайлинг сэтгэл зүйн

хөрөг, полиграф зэрэг мэдлэгийг нэмэлтээр заах. улмаар дээрх чиглэлээр эрдэм шинжилгээ судалгааны ажлыг нарийвчлан хийх зайлшгүй шаардлага бий болжээ.

Иймээс Хууль сахиулахын их сургуульд бүх мэргэжлийн шинжээчийг бэлтгэх, давтан сургах, боловсролын зэрэг ахиулах сургалтын нэгдсэн тогтолцоог бий болгох нь нэн тэргүүнд тавигдах нь гарцаагүй юм.

Шинжлэн магадлахуйн салбарын шинжээч бэлтгэх сургалтад дараах үндсэн гурван чиглэлийн хөтөлбөр байх нь зохистой гэж судлаачийн зүгээс үзэж байна.

1. Шүүхийн шинжилгээний мэргэжлийн шинжээч бэлтгэх бакалаврын сургалтын хөтөлбөр (гарын мөр, бичиг судлал, галт зэвсэг, мөр судлалын шинжээч г.м);

2. Шүүхийн шинжилгээний байгууллагад ажиллах бусад мэргэжлийн шинжээч бэлтгэх хөтөлбөр (шүүх эмнэлэг, шүүх сэтгэц, шүүх-нягтлан бодох, хими, биологи, физик, инженер, техникийн шинжээч г.м)

3. Шүүхийн бус шинжилгээний байгууллагад ажиллах шинжээч бэлтгэх хөтөлбөр (гааль, мэргэжлийн хяналт, онцгой байдал, эрхийн бүртгэл, хил хамгаалах байгууллагад ажиллах төрөл мэргэжлийн шинжээч)

Шинжээчийн бусад мэргэжилтнээс ялгарах гол онцлог бол тэд тусгай мэдлэг эзэмшсэн байх явдал юм. Иймд дээрх хөтөлбөрүүдийн гол зорилго бол суралцагчдад тусгай мэдлэгийг эзэмшүүлэхэд чиглэнэ. Шүүхийн шинжилгээний байгууллагын шинжээч нь хуулаар хүлээсэн үндсэн хоёр чиг үүргийг хэрэгжүүлдэг.¹

1. Эрх бүхий этгээдийн даалгаснаар тусгай мэдлэгийнхээ хүрээнд шинжилгээ хийж дүгнэлт гаргах

2. Зохих этгээдийн хүсэлтээр байцаан шийтгэх тодорхой ажиллагаанд мэргэжилтнээр оролцох.

Төгсөгчийн эзэмших мэдлэг, ур чадвар, хандлагыг тодорхойлоход хуульд заасан шинжээчийн эрх, үүрэг болон төв, орон нутгийн шүүхийн шинжилгээний албанд ажиллах шинжээчийн ажлын байрны тодорхойлолт, мэргэжилтний загварыг бас харгалзан үзэж бэлтгэх ёстой.

Шинжээчээр томилох гол үндсэн шалгуурын нэг нь мэргэшсэн байх явдал. Зүй нь шинжилгээний аль нэг төрлөөр мэргэшсэн хүнийг шинжээчээр томилно. Мэргэшсэн гэдэг нь сургууль төгсөхөд тодорхой төрлийн шинжилгээ хийх эрх олгосон гэрчилгээ баталгаажна. Харин сургууль төгссөний дараа төрөлжсөн нарийн мэргэжил болон мэргэжил дээшлүүлэх сургалтанд хамрагдаж байж бусад эрх олгогдоогүй шинжилгээ хийх эрх олгодоно гэсэн үг. Шинжээч

¹Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2,6.1.3 дахь заалт.

мэргэжлийн зэрэг, албан тушаал ахих нэг үндэслэл нь шаталсан сургалтаар бэлтгэгдсэн байх явдал юм.

ДҮГНЭЛТ: Аливаа байгууллага хөгжин дэвжих, үйл ажиллагаагаа амжилттай явуулахын үндэс суурь нь хүний нөөцийг зөв удирдан зохион байгуулж, сургаж хөгжүүлэхээс ихээхэн шалтгаалдаг. Иймээс хүний нөөцийг сургаж бэлтгэхэд сургалтын хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж, цаг үеэ олсон мэдлэг чадварыг тохирсон арга барилаар ойлгомжтой, хүртээмжтэй хүргэж, үнэлж дүгнэн үр дүнг тооцдог эргэх холбоотой үйл ажиллагаа явуулах нь чухал юм.

Иймд алба хаагчдыг сургах, мэргэшүүлэх, давтан сургах, мэдлэг ур чадвараа дээшлүүлэх боломж, нөхцлөөр хангаж тэднийг дэмжих нэгдсэн бодлого, төлөвлөлтийг тэдний бодит хэрэгцээнд тулгуурлан зохион байгуулах шаардлагатай байна. Алба хаагчдийг сургах ажлыг зохион байгуулах хэлбэр, сургалтын хөтөлбөрийг онол, практикийн үндсэн дээр боловсруулах, хэрэгжилтийн үр дүнг тухай бүр тооцох тогтолцоог бий болгох, улмаар суралцагчдын эзэмшсэн мэдлэг, ур чадварыг бодитоор үнэлж, урамшуулдаг, хариуцлага тооцдог, цаашдын хэрэгцээ шаардлагаа тодорхойлдог орчинг бүрдүүлэх нь нэн шаардлагатай байна.

Өндөр хөгжилтэй орнуудын Шүүхийн шинжилгээний байгууллагын сургалтын зохион байгуулалтын талаарх харьцуулсан судалгаанаас үзэхэд хөтөлбөр нь хэрэглээний чиглэлд илт хөгжсөн бөгөөд бодит сургалтын арга буюу дүрд тоглох, хэлэлцүүлэг өрнүүлэх, асуудал шийдвэрлэх, харилцан суралцах орчинд ажиллах зэрэг аргуудыг өргөн хэрэглэж, алба хаагчдын мэдлэг, чадвар, дадлыг хянах хатуу тогтолцоог суралцагчдад итгэх итгэлтэй нягт хослуулдаг онцлогтой байна. Мөн сургалтын бүх үйл ажиллагааны явцад эх оронч хүмүүжил олгоход онцгой анхаарч ажилладаг нь албандаа үнэнч шударга, тогтвор суурьшилтай ажиллах үндэс суурь болдог аж.

Иймээс Шүүхийн шинжилгээний байгууллага нь нэгэнт бэлтгэгдсэн хүний нөөцийг байгууллагын үнэ цэнэтэй, давтагдашгүй, орлуулах боломжгүй нөөц гэж хүлээн зөвшөөрч хүний нөөцийг үр ашигтай бүрдүүлэх, тэдний мэдлэг, ур чадварыг байнга дээшлүүлэн мэдлэгт суурилсан суралцагч байгууллагыг бий болгон ажиллахад голлон анхаарч ажиллах нь зүйтэй хэмээн дүгнэж байна.